

## **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2008 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2008.05.10  
хот

Улаанбаатар

### **НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Тайлант улиралд шинээр 5 ХХК-нд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны тогтоолоор олгож, нэр бүхий 11 ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны тогтоолоор хүчингүй болгосноор нийт 131 ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан хамрагдлаа.

Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээг ББСБ-уудын эрхэлж буйгаар нь ангилахад зээлийн үйл ажиллагаа 129, факторингийн үйлчилгээ 8, санхүүгийн түрээсийн үйлчилгээ 6, төлбөрийн баталгаа гаргах 5, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах 1, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 9, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа 54, итгэлцлийн үйлчилгээ 13, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх 3, хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ 4 ББСБ эрхэлж байна.

Орон нутагт 21 ББСБ ХХК үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-уудын 16.0 хувийг, тэдгээрийн нийт актив 2,009.3 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын активын 2.9 хувийг, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 1,482.0 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 3.4 хувийг тус тус эзэлж байгаа ба байршлын хувьд авч үзвэл Дорнод аймагт 4, Орхон, Дархан-Уул аймагт 3, Хөвсгөл, Төв зэрэг аймгуудад тус бүр 2, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Архангай, Баянхонгор, Хэнтий, Дорноговь зэрэг аймгуудад тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 11 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.4 хувийг, тэдгээрийн нийт актив 15,841.5 сая төгрөгт хүрсэн нь ББСБ-ын нийт активын 22.4 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив 4,178.5 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 11.6 хувийг тус тус эзэлж байна.

Харьяалалаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1 */Зөн сан Монгол/*, Япон улсын хөрөнгө оруулалттай 4 */Марико, Сар шинэ интернейшнл, Цагаан ажнай/*, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хөрөнгө оруулалттай 1 */Ийст Уэст факторинг/*, БНХАУ, БНСУ, Казахстан болон Италийн 100 хувийн ба хамтарсан хөрөнгө оруулалттай 8 */Футур эволюшн, Би И Ай, Халык Астана Дорнод/* ББСБ үйл ажиллагаа явуулж байна.


Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ч үйл ажиллагаа явуулж эхлээгүй болон 2008 оны нэгдүгээр улирлын санхүүгийн тайлан ирүүлээгүй 12 ББСБ ХХК-ийг өмнөх улирлуудын болон эхлэлтийн тайлангаар нэгтгэлд хамруулсан нь нийт ББСБ-уудын 9.2 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд Улаанбаатар хот болон орон нутаг дахь ББСБ-ын нийт салбар, нэгжийн тоо 46, нийт хувь нийлүүлэгчдийн тоо 436, нийт ажиллагсдын тоо 633 гаруйд хүрсэн ба давхардсан тоогоор 32.6 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээг үзүүлжээ.

Судалгаанаас үзэхэд ББСБ-уудын олгож буй зээлийн хүүгийн түвшин дундажаар 3.0-4.5 хувь, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрт төлж буй хүүгийн түвшин дундажаар 0.5-2.0 хувь байна.


## ХОЁР. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Тайлант улиралд нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 0.65 хувиар, хүүгийн орлого авчирдаг актив 31,986.1-36,143.2 сая төгрөг болж өссөнтэй холбоотойгоор нийт орлого өмнөх оны мөн үеэс *өмнөх оны мөн үед нийт орлого 3,302.2 сая төгрөг* 25.7 хувь буюу 849.6 сая төгрөгөөр өсч 4,151.8 сая төгрөгт хүрсэн ба дараах бүтэцтэй байна. Үүнд:



Нийт орлогын 62.7 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байгаа нь ББСБ-уудын хувьд зээлийн хүүгийн орлого нь нийт орлогын гол эх үүсвэр болсоор байгааг, түүнчлэн гадаад валютын арилжааны болон ханшийн тэгшитгэлийн орлого нийт орлогын 26.6 хувийг тус тус эзэлж байгаа нь гадаад валютын арилжааны үйл ажиллагааг ББСБ-ууд идэвхитэй эрхэлж байгааг тус тус харуулж байна.

Нийт зардал өмнөх оны мөн үеэс *өмнөх оны мөн үед нийт зардал 2,489.7 сая төгрөг* зардал зүйл тус бүрээр өссөнөөр, нийт зардал 3.9 хувь буюу 128.8 сая төгрөгөөр өсч 3,448.0 сая төгрөгт хүрсэн ба дараах бүтэцтэй байна. Үүнд:



ББСБ-ууд нийт 703.8 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад *өмнөх оны мөн үеийн цэвэр ашиг 721.4 сая төгрөг* 17.6 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант хугацаанд тодорхой хэмжээгээр ашигтай ажилласан 103 ББСБ байгаа нь нийт ББСБ-ын 78.6 хувийг эзэлж байгаа ба тэдгээрийн ашиг 17.2 мянган төгрөгөөс 122.9 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Харин 24 ББСБ буюу нийт ББСБ-уудын 18.3 хувь нь 8.0 мянган төгрөгөөс 288.3 сая төгрөг хүртэл алдагдалтай ажилласан байна.

Түүнчлэн ББСБ-ууд нийт 2,160.6 сая төгрөгийн ашгийг хуримтлуулан тооцсон байна.

## ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 3.1 Активын өөрчлөлтийн талаар

Нийт эх үүсвэр нэмэгдсэнээр нийт актив өмнөх оны мөн үеэс 0.65 хувиар өссөн ба нийт активын бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна.

Тухайлбал, хүүгийн орлого авчирдаг активуудын дүн 31,986.1-36,143.2 сая төгрөг болж өссөн ба орлого авчирдаг активын өсөлтийн хурдац нь нийт активын өсөлтийн хурдацаас их байгаагаас нийт активт эзлэх хувийн жин нь 45.6-51.2 хувь болж өссөн. Харин ББСБ-уудын үндсэн хөрөнгийн хэмжээ 2.5 дахин буурсанаар эргэлтийн бус хөрөнгийн нийт активт эзлэх хувийн жин 15.6-6.2 хувь болж буурсан байна.

Тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ		Тайлант үе		Өмнөх оны мөн үе		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>A</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>66,225,097.8</b>	<b>93.8</b>	<b>58,976,328.0</b>	<b>84.1</b>	<b>7,248,769.8</b>	<b>9.7</b>
1	Мөнгөн хөрөнгө	19,462,358.5	27.6	20,494,258.3	29.2	-1,031,899.9	(1.7)
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	4,286,696.9	6.1	4,211,252.0	6.0	75,444.9	0.1
3	Нийт зээл	36,138,324.4	51.2	30,936,778.6	44.1	5,201,545.9	7.1
	Зээл /цэврээр/	34,855,902.5	49.4	29,803,591.0	42.5	5,052,311.4	6.9
	<i>Нийт зээл (төгрөгийн)</i>	<i>32,546,445.7</i>	<i>46.1</i>	<i>24,570,000.9</i>	<i>35.0</i>	<i>7,976,444.8</i>	<i>11.1</i>
	<i>Нийт зээл (валютын)</i>	<i>3,591,878.8</i>	<i>5.1</i>	<i>6,366,777.7</i>	<i>9.1</i>	<i>-2,774,898.9</i>	<i>(4.0)</i>
	<i>(Зээлийн эрсдлийн сан)</i>	<i>1,282,422.0</i>	<i>1.8</i>	<i>1,133,187.5</i>	<i>1.6</i>	<i>149,234.4</i>	<i>0.2</i>
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	4,462.1	0.0	418,540.3	0.6	-414,078.2	(0.6)
	<i>(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)</i>	<i>68.1</i>	<i>0.0</i>	<i>25,523.7</i>	<i>0.0</i>	<i>-25,455.6</i>	<i>(0.0)</i>
5	Нийт факторингийн тооцооны авлага	350.0	0.0	0.0	-	350.0	0.0
	<i>(Факторингийн авлагын эрсдлийн сан)</i>	<i>350.0</i>	<i>0.0</i>	<i>350.0</i>	<i>0.0</i>	<i>0.0</i>	<i>(0.0)</i>
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	221,487.2	0.3	0.0	-	221,487.2	0.3
	<i>Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө</i>	<i>193,688.2</i>	<i>0.3</i>	<i>346,088.5</i>	<i>0.5</i>	<i>-152,400.3</i>	<i>(0.2)</i>
	<i>(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдлийн сан)</i>	<i>93,498.1</i>	<i>0.1</i>	<i>96,398.6</i>	<i>0.1</i>	<i>-2,900.5</i>	<i>(0.0)</i>
	<i>Өмчлөх бусад хөрөнгө</i>	<i>121,297.1</i>	<i>0.2</i>	<i>0.0</i>	<i>-</i>	<i>121,297.1</i>	<i>0.2</i>
7	Бусад хөрөнгө	7,394,258.7	10.5	0.0	-	7,394,258.7	10.5
	<i>Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага</i>	<i>867,868.6</i>	<i>1.2</i>	<i>794,216.0</i>	<i>1.1</i>	<i>73,652.5</i>	<i>0.1</i>
	Нийт авлага	<i>3,170,221.1</i>	<i>4.5</i>	<i>908,062.1</i>	<i>1.3</i>	<i>2,262,158.9</i>	<i>3.2</i>
	<i>(Авлагын эрсдлийн сан)</i>	<i>3,551.2</i>	<i>0.0</i>	<i>20,644.5</i>	<i>0.0</i>	<i>-17,093.3</i>	<i>(0.0)</i>
	Бусад актив	3,359,720.3	4.8	1,731,531.2	2.5	1,628,189.2	2.3
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	0.0	-	9,934.5	0.0	-9,934.5	(0.0)
<b>B</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>4,363,247.9</b>	<b>6.2</b>	<b>10,907,114.7</b>	<b>15.6</b>	<b>-6,543,866.8</b>	<b>(9.4)</b>
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	4,363,247.9	6.2	10,907,114.7	15.6	-6,543,866.8	(9.4)
	<i>Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө</i>	<i>5,301,423.6</i>	<i>7.5</i>	<i>11,586,874.3</i>	<i>16.5</i>	<i>-6,285,450.7</i>	<i>(9.0)</i>
	<i>(Хуримтлагдсан элэгдэл)</i>	<i>938,175.7</i>	<i>1.3</i>	<i>679,759.7</i>	<i>1.0</i>	<i>258,416.0</i>	<i>0.4</i>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>70,588,345.6</b>	<b>100.0</b>	<b>70,133,132.5</b>	<b>100.0</b>	<b>455,213.1</b>	<b>-</b>

### 3.2 Активын багцын чанар

Зээл, санхүүгийн түрээс, факторингийн үйлчилгээний өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 13.0 хувиар буюу 4,157.0 сая төгрөгөөр өсч 36,143.2 сая төгрөгт хүрсэн нь нийт активын 51.2 хувийг эзэлж байна.


Эрсдэлтэй активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлтүүд	Тайлант үе	Өмнөх оны мөн үе	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
1	<b>Хэвийн</b>	<b>41,355,367.35</b>	<b>34,546,421.23</b>	<b>6,808,946.12</b>	19.7
2	<b>Хугацаа хэтэрсэн</b>	<b>773,897.44</b>	<b>1,242,079.51</b>	<b>(468,182.07)</b>	(62.3)
3	<b>Чанаргүй. Үүнээс:</b>	<b>1,664,477.89</b>	<b>1,589,458.66</b>	<b>75,019.23</b>	4.7
	<i>а/ Хэвийн бус</i>	<i>372,535.50</i>	<i>558,045.64</i>	<i>(185,510.14)</i>	(33.2)
	<i>б/ Эргэлзээтэй</i>	<i>29,493.65</i>	<i>333,559.42</i>	<i>(104,065.77)</i>	(31.2)
	<i>в/ Муу</i>	<i>1,062,448.73</i>	<i>697,853.59</i>	<i>64,595.14</i>	52.2
	<b>НИЙТ</b>	<b>43,793,742.68</b>	<b>37,377,959.41</b>	<b>6,415,783.27</b>	17.1

Тайлант хугацаан дахь ББСБ-уудын нийт ктивын чанарын бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/



## ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТАЛААР

### 4.1 Нийт эх үүсвэрийн өөрчлөлтийн талаар

Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ 38.1 хувиар буурсан, харин бусад өр төлбөр 3.9 дахин, эзэмшигчдийн өмч 4.7 хувиар тус тус нэмэгдсэнээр нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 0.65 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Түүнчлэн нийт эх үүсвэрийн бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон. Тухайлбал, итгэлцлийн үйлчилгээний 29.9 хувиар, мөнгөн гуйвуулгын тооцооны өглөг 1.6 дахин буурснаар нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 4.8-3.4, 4.4-2.8 хувь болж тус тус буурсан, харин ББСБ-ын нягтлан бодох бүртгэлийн журам шинэчлэгдэн батлагдсанаар эзэмшигчдийн бусад өмч хэсэгт бүртгэгдэж байсан дүн, мөн Хорооны зөвшөөрөлгүй дүрмийн санд нэмж оруулсан хөрөнгийг бусад пассив оруулж тохируулан тооцооноор бусад пассив 4.0 дахин өсч, нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 2.5-9.8 хувь болж өссөн байна.

Харин өөрийн хөрөнгийн хэмжээ хувьцаат капиталын өсөлтөөс шалтгаалж нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин нь 65.8-68.6 хувь болж өссөн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдац нь нийт эх үүсвэрийн өсөлтийн хурдацаас их байгаатай холбоотой бөгөөд нийт эх үүсвэрийн 68.6 хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлж байгаа нь бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх явц нь зохистой түвшинд байгааг харуулж байна.

Тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		Тайлант үе		Өмнөх оны мөн үе		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>A</b>	<b>Өр төлбөр</b>	<b>15,014,206.0</b>	<b>21.3</b>	<b>22,123,894.8</b>	<b>31.5</b>	<b>-7,109,688.8</b>	<b>(10.3)</b>
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,369,641.4	3.4	3,380,480.2	4.8	-1,010,838.8	(1.5)
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	7,844,190.5	11.1	12,691,102.3	18.1	-4,846,911.7	(7.0)
3	Бусад эх үүсвэр	2,088,026.2	3.0	6,603,815.5	9.4	-4,515,789.3	(6.5)
	Зээлийн батлан даалганд байршуулсан эх үүсвэр	16,199.4	0.0	41,074.5	0.1	-24,875.1	(0.0)
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	1,963,151.2	2.8	3,055,374.5	4.4	-1,092,223.3	(1.6)
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	54,455.5	0.1	0.0	0.0	54,455.5	0.1
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	54,220.1	0.1	0.0	0.0	54,220.1	0.1
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	0.0	-	0.0	0.0	0.0	-
5	Төслийн зээлийн санхүүжилт	2,712,348.0	3.8	2,787,902.6	4.0	-75,554.7	(0.1)
	<b>Бусад өр төлбөр</b>	<b>7,156,409.0</b>	<b>10.1</b>	<b>1,857,885.1</b>	<b>2.6</b>	<b>5,298,523.8</b>	<b>7.5</b>
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	221,112.4	0.3	130,788.9	0.2	90,323.5	0.1
7	Бусад пассив	6,935,296.5	9.8	1,727,096.2	2.5	5,208,200.3	7.4
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	-	0.0	0.0	0.0	-
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>22,170,615.0</b>	<b>31.4</b>	<b>23,981,780.0</b>	<b>34.2</b>	<b>-1,811,164.9</b>	<b>(2.8)</b>
<b>B</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>48,417,730.6</b>	<b>68.6</b>	<b>46,151,352.5</b>	<b>65.8</b>	<b>2,266,378.1</b>	<b>2.8</b>
9	Хувьцаат капитал	43,082,678.8	61.0	41,400,442.3	59.0	1,682,236.5	2.0
	Ердийн хувьцаа	42,837,828.8	60.7	41,285,762.2	58.9	1,552,066.6	1.8
	Давуу эрхтэй хувьцаа	244,850.0	0.3	114,680.1	0.2	130,169.9	0.2
10	Бусад өмч	590,362.0	0.8	224,910.0	0.3	365,452.0	0.5
	Нэмж төлөгдсөн капитал	5,000.0	0.0	224,630.0	0.3	-219,630.0	(0.3)
	Дахин үнэлгээний нэмэгдэл	417,547.1	0.6	280.0	0.0	417,267.1	0.6
	Хандивын капитал	167,814.9	0.2	0.0	0.0	167,814.9	0.2
11	Сангууд	1,142,835.8	1.6	967,029.1	1.4	175,806.7	0.2
	Нөөцийн сан	1,091,326.1	1.5	924,148.2	1.3	167,177.8	0.2
	Нийгмийн хөгжлийн сан	51,509.7	0.1	42,880.8	0.1	8,628.9	0.0
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	2,864,393.9	4.1	2,373,435.9	3.4	490,958.1	0.7
	Тухайн үеийн ашиг/алдагдал	703,776.8	1.0	723,787.3	1.0	-20,010.5	(0.0)
	Хуримтлагдсан ашиг/алдагдал	2,160,617.1	3.1	1,649,648.6	2.4	510,968.6	0.7
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	737,460.1	1.0	1,185,535.3	1.7	-448,075.2	(0.6)
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>70,588,345.6</b>	<b>100.0</b>	<b>70,133,132.5</b>	<b>100.0</b>	<b>455,213.1</b>	<b>-</b>

төгрөгөөр/

## ТАВ. ДҮГНЭЛТ

ББСБ-уудын нийт актив 2008 оны нэгдүгээр улирлын байдлаар **70,588.4** сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын **/банкны салбарын нийт актив 3,485,730.3 сая төгрөг/** 2.0 хувьтай тэнцэж байгаа ба активын өгөөж **4.7 /ROA/** хувь байна.

Өөрийн хөрөнгө **48,417.7** сая төгрөгт хүрсэн нь нийт банкны салбарын эзэмшигчдийн өмчийн */эзэмшигчийн өмч 387,719.1 сая төгрөг/* 12.5 хувьтай тэнцэж байгаа ба өөрийн хөрөнгийн өгөөж 2.3/ROE/ хувь байна.

ББСБ-уудын нийт олгосон зээл, түүнтэй адилтгах активын хэмжээ **43,793.7** сая төгрөг байгаа банкны салбарын нийт олгосон зээлийн */2,366,511.0 сая төгрөг/* 1.67 хувьтай тэнцэж байна.

## БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР